

baigal - orchin @ yahoo.com.
70543063 BOAJG
munkh139@gmail.com.



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/29

Чойр

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
дүрмийг шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 67 дугаар тогтоол болон уг тогтоолд өөрчлөлт оруулах тухай 2015 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын шинэчилсэн бүтцийн дагуу аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагуудын бүтэц шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дүрмийг 1 дүгээр хавсралтаар, ажил үүргийн чиглэлийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Д.МӨНХ-ЭРДЭНЭ/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2013 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/148 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Л.ОДСЭР



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг: Нийтлэг үндэслэл

1.1. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь /цаашид "газар" гэнэ/ Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 67 дугаар тогтоол, 2015 оны 01 дүгээр сарын 12-ний өдрийн 08 дугаар тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий бүтэц, орон тоо, удирдлагын бүдүүвчийн дагуу байгуулагдсан аймгийн нутаг дэвсгэрт байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар явуулж байгаа төрийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, сүм орон нутаг, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд мэргэжлийн арга зүйн туслацаа үзүүлэх үүрэг бүхий орон нутгийн төрийн захиргааны байгууллага мөн.

1.2. Газрын үндсэн зорилго нь Байгаль орчин, аялал жуулчлалын хууль тогтоомжийг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, Байгаль хамгаалах, байгалийн тогтоомжийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчин, аялал жуулчлалын мэдээллийн сан бүрдүүлэх, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх, ус цаг уур, орчны шинжилгээний ажилд дэмжлэг үзүүлэх, байгаль орчин, аялал жуулчлалын сургалт, судалгаа, сурталчилгааны ажлыг гүйцэтгэхэд оршино.

1.3. Газар нь аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Засгийн газрын холбогдох агентлагуудаас, иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын бодлого, тогтоол, шийдвэр, энэхүү дүрмийг удирдлага болон тусгай хамгаалалттай газрын хамгаалалттай газар болон Усны сав газрын захиргаа, аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэстэй ажлын үйлдвэр хангаж ажиллана.

1.4 Газар нь аймгийн хэмжээний байгаль орчныг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар тогтоол хангаж, хэрэглэгчдийг байгаль орчин, аялал жуулчлалтай холбогдолтой мэдээллээр хангах экологийн боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

Хоёр: Газрын удирдлага, бүтэц

1. Газар нь үүрэг, зорилгоо хэрэгжүүлэх, ажлын уялдаа холбоот хангах асуудлаар газрын даргад зөвлөх эрх бүхий зөвлөлийг ажиглуулах бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүнд цаг уур орчны ТХН-ын ХЗ-ны дарга, Сав газрын захирааны дарга, аймгийн хөгжлийн бодлогын хэлтсийн байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнийг оруулна. Зөвлөлийг газрын дарга удирдаж,

бүрэлдэхүүн, ажиллах журмыг өөрийн тушаалаар батална.

2. Газрын дарга нь дор дурдсан эрх, үүрэгтэй ажиллана. Үүнд:

2.1 Газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.

2.2 Газрын дотоод нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, ажлын байрны тодорхойлолтыг батлах, бүтээгдэхүүн нийлүүлэх зарчмаар ажилтнуудтай үр дүнгийн гэрээ байгуулж ажиллах.

2.3 Газрын албан хаагчдыг зохих журмын дагуу томилох, чөлөөлөх, ажилтнуудыг шагнах, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлүүлэх.

2.4 Батлагдсан төсвийг захиран зарцуулах.

2.5 Газрын нэрийн өмнөөс бусад байгууллагуудтай харилцах, хамтран ажиллах.

2.6 Эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах

2.7 Газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргыг бүрэн хангах.

2.8 Сум, сум дундын ойн ангийг харьяалах.

Гурав. Газрын үйл ажиллагааны чиглэл

а. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах

1. Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, "Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал" хөтөлбөр, Улсын Их Хурал, Засгийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын шийдвэрээр батлагдсан байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлийн бодлогын баримт бичиг, хөтөлбөр, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, "Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт"-т байгалийн нөөц баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гаргасан зарлигийг орон нутагт хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг ханган ажиллах.

3. Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн дагуу орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих.

4. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын дүрэм, журам, стандартуудыг мөрдүүлэх, сурталчлах, хэрэгжилтэнд хяналт тавих.

5. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан байгаль орчин, аялал жуулчлалын бодлогыг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээнд тусгагдсан тодорхой арга хэмжээг хариуцан зохион байгуулах.

6. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх замаар санхүүгийн баталгаатай эх үүсвэрийг буй болгож, эдгээр хөрөнгөөр аймаг, сум,

① - аялал жуулчлал, байгалийн нөөц баялгийг хамгаалах, зүй зохистой

бүрэлдэхүүн, ажиллах журмыг өөрийн тушаалаар батална.

2. Газрын дарга нь дор дурдсан эрх, үүрэгтэй ажиллана. Үүнд:

2.1 Газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.

2.2 Газрын дотоод нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, ажлын байрны тодорхойлолтыг батлах, бүтээгдэхүүн нийлүүлэх зарчмаар ажилтнуудтай үр дүнгийн гэрээ байгуулж ажиллах.

2.3 Газрын албан хаагчдыг зохих журмын дагуу томилох, чөлөөлөх, ажилтнуудыг шагнах, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлүүлэх.

2.4 Батлагдсан төсвийг захиран зарцуулах.

2.5 Газрын нэрийн өмнөөс бусад байгууллагуудтай харилцах, хамтран ажиллах.

2.6 Эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах

2.7 Газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргыг бүрэн хангах.

2.8 Сум, сум дундын ойн ангийг харьяалах.

Гурав. Газрын үйл ажиллагааны чиглэл

а. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах

1. Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, "Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал" хөтөлбөр, Улсын Их Хурал, Засгийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын шийдвэрээр батлагдсан байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлийн бодлогын баримт бичиг, хөтөлбөр, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, "Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт"-т байгалийн нөөц баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гаргасан зарлигийг орон нутагт хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг ханган ажиллах.

3. Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн дагуу орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих.

4. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын дүрэм, журам, стандартуудыг мөрдүүлэх, сурталчлах, хэрэгжилтэнд хяналт тавих.

5. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан байгаль орчин, аялал жуулчлалын бодлогыг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээнд тусгагдсан тодорхой арга хэмжээг хариуцан зохион байгуулах.

6. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх замаар санхүүгийн баталгаатай эх үүсвэрийг буй болгож, эдгээр хөрөнгөөр аймаг, сум,

① - аймгийн нутагтай, байгалийн нөөц баялгийг хамгаалах, зүй зохистой

17. Аймгийн ойн сангийн ой зохион байгуулалтыг явуулж, өөрчлөлтийн тооцон мэдээлэх, ойн ашиглалт, хамгаалалтын бүс, хот суурин газрын ногоон бүсийг тогтооход санал өгөх, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд ойн санг эзэмшүүлэх, ашиглуулах талаар баримт материал бүрдүүлэх, гэрээ байгуулах, батламжлуулахад мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх, ойн хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилтэнд технологийн хяналт тавьж, зөрчлийг арилгуулах;

18. Аймаг, бүс нутгийн байгаль орчинд зохицсон, зохих материаллаг бааз бүхий мод ургамлын үржүүлгийн газар байгуулж, тарьц, суулгац ургуулах, мод сөөгийн үрийн нөөц сан бүрдүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах замаар сайн чанарын үр, тарьц суулгац бэлтгэж орон нутгийн хэрэгцээг хангах;

19. Ховор, нэн ховор ургамлыг тарималжуулах ажлыг зохион байгуулах;

20. Усны нөөц, эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч, зарим гол нуурын усыг салаалах, шар усыг тогтоон барих, борооны усыг хуримтлуулж усан сан байгуулах зэрэг арга хэмжээг нутаг орны байдалд тохируулан холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор зохион байгуулах;

21. Бүх төрлийн худгуудын ашиглалтад хяналт тавих, эзэн хариуцагчтай болгох ажлыг хариуцан зохион байгуулах, усны чиглэлийн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

22. Агаарын бохирдол, хог хаягдал, химийн бодисын менежмент, био аюулгүй байдлын асуудлаар бодлогын хэрэгжилтийг хангах, агаар, ус, хөрсийг бохирдлоос хамгаалах, хяналт-шинжилгээ хийх асуудлыг хариуцан зохион байгуулах, энэ ажилд ус, цаг уурын орчны шинжилгээний албыг татан оролцуулах

23. Ой, хээрийн түймэр зэрэг байгалийн гамшгаас иргэдийн амь нас, байгалийн нөөц баялгийг урьдчилан сэргийлэх, хамгаалах багаж, тоног төхөөрөмж, хэрэгслийн нөөцтэй байх, ой, хээрийн түймрээс сэргийлэх ажлыг зохион байгуулах, экосистемд учирсан хохирлын талаар мэргэжлийн дүгнэлт гаргуулах, хохирлыг нөхөн төлүүлэх талаар хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллах.

в. Байгаль орчны мэдээллийн сан бүрдүүлэх чиглэлээр

24. "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 37 дугаар зүйлийн 37.1 дэх заалтуудыг жишиг болгон байгаль орчны мэдээллийн улсын сангийн мэдээ, баримтыг бүрдүүлэн Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яаманд хуулийн хугацаанд ирүүлж байх;

25. Байгалийн нөөц баялгийн талаарх мэдээллийн сангийн үйл ажиллагааг эрхлэн, холбогдох байгууллага, иргэдэд байгаль орчны мэдээллээр үйлчлэх;

26. Байгаль орчин, ногоон хөгжлийн холбогдолтой судалгаа, шинжилгээний ажил эрхлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгүүлэх, үр дүнг хүлээн авах;

27. Аймгийн нутаг дэвсгэрт байгаа ой, ус, ургамал, ан амьтан зэрэг байгалийн нөөц баялаг, түүнээс ашиглаж болох тоо хэмжээг нарийвчлан тогтоолгох, зөвшөөрөгдсөн хэмжээнд ашиглуулах;

28. Аймгийн усны нөөц, түүний зохистой ашиглалт, хэрэглээний байдлыг тогтмол үнэлж усны мэдээллийн сан байгуулах, гадаргын усны тооллого хийх, ширгэж хатсан гол горхи, рашаан, булаг, шандны тоо, мэдээллийг гаргах, холбогдох дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах;

Дөрөв: Газрын санхүүжилт

1. Газрын санхүүжилт нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

1/ Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээнд заасан тухайн жилд арга хэмжээнд зориулан улсын төсвөөс олгосон хөрөнгө;

2/ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай" Монгол Улсын хуулиар зохицуулагдах хөрөнгийн тодорхой хэсэг;

3/ Орон нутагт байгалийн баялгийг нөхөн сэргээх, хамгаалах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан хандив, тусламж, олон улсын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө;

4/ Газрын өөрийн хөрөнгө, хууль тогтоомжийн хүрээнд явуулсан үйл ажиллагааны орлого.

Аймгийн Засаг даргын 2015 оны 02 дүгээр сарын
09-ны өдрийн 1129 тоот захирамжийн 2 дугаар хавсралт

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
ГАЗРЫН АЖИЛТНУУДЫН АЖИЛ ҮҮРГИЙН ЧИГЛЭЛ**

№	Ажлын байр	Ажил үүргийн хуваарь
1	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга ТЗ-9	<p>Нэг. Удирдан зохион байгуулах</p> <ol style="list-style-type: none">Газрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулахЭрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулахГазрын мэргэжилтнүүдийн үйл ажиллагааны чиглэл, ажлын байрны тодорхойлолотыг батлах, бүтээгдэхүүн нийлүүлэх зарчмаар төрийн захиргааны албан хаагчтай үр дүнгийн гэрээ, үйлчилгээний албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ тус тус байгуулж, үр дүнг дүгнэхАжилтнуудыг томилох, чөлөөлөх, шагнах, урамшуулах, дээд байгууллагын шагналд тодорхойлохГазрын үйл ажиллагаатай холбогдолтой гарсан хууль, тогтоомж, УИХ, Засгийн газар, яам, агентлаг болон орон нутгийн удирдах байгууллагын тогтоол, тушаал, шийдвэрийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд сурталчлах, хэрэгжүүлэх, төсвийн тухай хуулийн дагуу үр дүнгийн гэрээ байгуулж, бүтээгдэхүүн нийлүүлэх зарчмаар зохион байгуулах <p>Хоёр. Төсөв санхүүгийн асуудал</p> <ol style="list-style-type: none">Батлагдсан хөрөнгийг зориулалтаар нь захиран зарцуулахБайгаль орчны санд хөрөнгө төвлөрүүлэх, улмаар баталгаатай эх үүсвэрийг буй болгож эдгээр хөрөнгөөр аймаг, сумын хэмжээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулахал оролцож, хэрэгжилтийг зохион байгуулахад хяналт тавьж ажиллах <p>Гурав. Газрыг төлөөлөн бусад байгууллагатай харилцах</p> <ol style="list-style-type: none">Газрын нэрийн өмнөөс бусад байгууллагуудтай харилцах, хамтран ажиллахБайгаль орчны чиглэлээр мэдээллээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, холбогдох албан тушаалтнуудыг бүрэн хангахСумын Засаг даргын аймгийн Засаг даргатай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусгах байгаль орчны ажлын чиглэл, шалгуур үзүүлэлтийг сум, сумын онцлогтой уялдуулан боловсруулж, Засаг дарга нарт дэмжлэг үзүүлэх

		<p>4. Газрын ажилтнуудын мэргэжил боловсролыг дээшлүүлэх, давтан сургах, дадлага, туршлагажуулахад туслалцаа үзүүлэх</p> <p>5. Байгаль орчны нөхөрлөлийн ахлагч нарт мэргэжлийн арга зүйн болон бусад чиглэлээр дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах</p> <p>6. Байгаль орчны зарим тулгамдсан асуудал бүрээр аймгийн дэд хөтөлбөр санаачлан боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах</p>
2	<p>Нягтлан бодох</p> <p>ТҮ-7</p>	<p>Нэг. Санхүүгийн удирдлага</p> <p>1. Байгууллагын болон салбарын санхүүгийн менежментийн асуудал</p> <p>2. Байгууллагын үйл ажиллагааны эдийн засгийн шинжилгээ дүгнэлт хийж үр дүнг сайжруулах</p> <p>Хоёр. Санхүүгийн бүртгэл</p> <p>1. Байгууллагын болон БХНСАХ зардлын санхүүгийн бүртгэл, тооцоо, тайлан, зардал хямдруулах, төсөв хэмнэх үйл ажиллагааг зохион байгуулах</p> <p>2. Төлбөр тооцоо, өглөг, авлагын барагдуулалт</p> <p>3. Өөрийн орлого</p> <p>4. Татвар нийгмийн даатгалтай холбоотой асуудал</p> <p>Гурав. Аж ахуйн асуудал</p> <p>1. Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн бүртгэл, тооцоо</p> <p>2. Нярав. Бичээч, жолооч нарын өдөр тутмын ажлын үр дүнг тооцох</p>
3	<p>Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын салбарын бодлогын хэрэгжилт, Ой ургамлын баялгын ашиглалт, хамгаалалт, цөлжилт, биологийн төрөл зүйл, сумдыг удирдлагаар хангах ажил хариуцсан ахлах мэргэжилтэн</p> <p>ТЗ-6</p>	<p>Нэг. Байгаль орчны салбарын бодлого</p> <p>1. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл брмтлал, монгол улсын хөгжлийн үзэл баримтлал, Төрөөс экологийн талаар баримтлах бодлого, Монгол улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Ногоон хөгжлийн үзэл баримтлал зэрэг суурь баримт бичгүүдэд тусгагдсан зорилтуудыг орон нутагт хэрэгжүүлэх хяналт шинжилгээ хийх, тайлан гаргаж танилцуулах</p> <p>2. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, УИХ, Засгийн газар, Байгаль орчны сайдын шийдвэрээр батлагдсан байгаль орчны чиглэлийн бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүд, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр-т байгалийн нөөц баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах, хяналт шинжилгээ хийх, биелэлтийг гаргаж тайлагнах</p> <p>Хоёр. Ой ургамлын баялгийн ашиглалт, хамгаалалт</p> <p>1. "Ойн тухай" үндэсний хөтөлбөр, "Монгол орчны</p>

		<p>ховор ургамлтыг хамгаалах, зохистой ашиглах” үндэсний хөтөлбөр, “Цөлжилттэй тэмцэх” үндэсний хөтөлбөр, “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн асуудал</p> <ol style="list-style-type: none"> 2. Ойн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах 3. Ой ургамалыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх арга хэмжээний хэрэгжилтэнд технологийн хяналт тавьж, зөрчлийг арилгуулах, төсвөөс хуваарилсан хөрөнгийн гүйцэтгэлд хяналт тавих тайлагнах 4. Ойн сангийн мэдээ тайлан <p>Гурав. Биологийн төрөл зүйлийн ашиглалт, хамгаалалт</p> <ol style="list-style-type: none"> 1. Ан амьтныг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомж, бусад шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах 2. Амьтны нөөц тогтоож, ашиглалтыг зохицуулах 3. Амьтныг сэргээн нутагшуулах, биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх 4. Биологийн төрөл зүйлүүдийг хамгаалах талаар гарсан үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн асуудал <p>Дөрөв. Сумдыг удирдлагаар хангах</p> <ol style="list-style-type: none"> 1. Сумдын өөрөө удирдах ёсны болон захиргааны байгууллагуудыг мэргэжлийн удирдлагаар хангах 2. Иргэд, аж ахуйн нэгж, төрийн албан хаагч, хувийн хэвшлийнхэнд зориулсан тэдний эрэлт хэрэгцээнд нийцүүлэн бодлого, хууль тогтоомжийг таниулан ойлгуулах аргачлал, зөвлөмж боловсруулан сумдад хүргэх <p>Тав. Нэмэлт үүрэг</p> <ol style="list-style-type: none"> 1. Ахлах мэргэжилтний үүрэгтэйгээр ажиллаж, Газрын даргыг байхгүй үед орлох, бусад мэргэжилтнүүдэд бодлогын арга зүйгээр хангах, зөвлөгөө өгч ажиллах
4	<p>Агаар, хог хаягдал, химийн хорт бодис, байгалийн гамшигийн асуудал хариуцсан мэргэжилтэн</p> <p>ТЗ-5</p>	<p>Нэг. Агаарын чанарын асуудал</p> <ol style="list-style-type: none"> 1. Агаарт бохирдолыг хянах түүнийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах 2. “Агаар хамгаалах” үндэсний хөтөлбөр, “Озоны давхрага хамгаалах” үндэсний хөтөлбөр, “Уур амьсгалын өөрчлөлтийн” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн асуудал <p>Хоёр. Хог хаягдал, химийн хорт бодисын асуудал</p> <ol style="list-style-type: none"> 1. Хог хаягдлын тухай хууль тогтоомж, хог хаягдлын талаархи төрийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын нормативыг тогтоож, нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх 2. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булах иргэн, аж

		<p>ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, санхүүжүүлэх журам болон сумын Засаг даргатай байгуулах гэрээний асуудал</p> <ol style="list-style-type: none"> Химийн хорт бодисын бүртгэл тооцоо, хэрэглээнд тавих хяналт Байгаль орчинд ээлтэй сайн туршлага, санаачлагын талаар судалгаа авах, дэлгэрүүлэх, урамшуулах асуудал <p>Гурав. Байгалийн гамшигийн асуудал</p> <ol style="list-style-type: none"> "Байгалийн гамшигийн аюулыг бууруулах" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн асуудал
5	<p>Усны нөөц ашиглалт, хамгаалалт, төрийн бус байгууллагуудтай ажиллах, Дотоод ажил, Мэдээллийн сан судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн</p> <p>T3-5</p>	<p>Нэг. Усны нөөц баялгийг хамгаалах</p> <ol style="list-style-type: none"> Усны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах Аймгийн усны мэдээллийн сан, усны тооллого Усны нөөцийг ашиглах, усны орчинг нөхөн сэргээх, хамгаалах, цэвэр ариун байлгах үйл ажиллагаа Ус ашиглах зөвшөөрлийн асуудал Усны үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн асуудал Ус ашиглалтын тоо бүртгэл Усны чанар, бохирдлын судалгаа <p>Хоёр. ТББ-уудтай ажиллах</p> <ol style="list-style-type: none"> Орон нутагт ажиллаж байгаа төрийн бус байгууллагууд, нөхөрлөлийн судалгаа гаргаж нэгтгэх, хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах <p>Хоёр. Дотоод ажил</p> <ol style="list-style-type: none"> Хүний нөөцийн судалгаа, тайлан Тайлан мэдээ, тогтоол шийдвэрийн биелэлт, <p>Нэг. Мэдээллийн сан</p> <ol style="list-style-type: none"> Байгалийн нөөц баялгийн мэдээллийн сангийн мэдээ баримтыг нэгтгэн бүрдүүлэх Статистик мэдээлэл <p>Гурав. Судалгаа шинжилгээний ажил</p> <ol style="list-style-type: none"> Байгалийн нөөц баялгийн эрдэм шинжилгээний ажлын чиглэл, төлөвлөгөө, гэрээ хэлэлцээрийн төсөл боловсруулан баталгаажуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Байгаль хамгаалагчдын ажиглалт судалгааг нэгтгэх, дүгнэлт хийх Судалгаа шинжилгээний мэдээллийн сан бүрдүүлэх, тайлагнах Аймгийн хэмжээнд явуулах шаардлагатай байгаа судалгаа шинжилгээний төслийн захиалга авах, үндэслэл бүхий санал боловсруулан танилцуулах
	Газар, газрын	Нэг. Газар, түүний хөрсийг хамгаалах

6	<p>хэвлий, түүний баялгийн ашиглалт, нөхөн сэргээлт, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хариуцсан мэргэжилтэн</p> <p>ТЗ-5</p>	<ol style="list-style-type: none"> Газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлого, газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах Газар эзэмшигч, ашиглагчаас газрыг ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгуулах Газрын нэгдмэл сангийн тайлан Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал <p>Хоёр. Газрын хэвлий түүний баялгийг хамгаалах</p> <ol style="list-style-type: none"> Ашигт малтмалын тухай хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг зохион байгуулах Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар нь ашиглуулах, зөрчил гаргавал таслан зогсоох <p>Гурав. Байгаль орчинд, нөлөөлөх байдлын үнэлгээний асуудал</p> <ol style="list-style-type: none"> Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хамруулж, байгаль хамгаалах төлөвлөгөө, хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
7	<p>Аялал жуулчлалын асуудал, Тусгай хамгаалалттай газар нутаг, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн</p> <p>ТЗ-5</p>	<p>Нэг. Аялал жуулчлалыг хөгжүүлэх</p> <ol style="list-style-type: none"> Орон нутагт аялал жуулчлал хөгжүүлэх үзэл баримтлал, бодлого, стратеги, төсөл, хөтөлбөр боловсруулах, бодлого зохицуултын удирдамжаар хангах, түүнийг хэрэгжүүлэх, зөвлөлгөөгөөр хангах Орон нутагт аялал жуулчлалын чиглэлийн сургалт, судалгааны ажлыг зохион байгуулах, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх Орон нутагт аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулах. <p>Хоёр. Тусгай хамгаалалттай газар нутаг</p> <ol style="list-style-type: none"> Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал хариуцан үйл ажиллагаа явуулах <p>Гурав. Сургалт сурталчилгаа</p> <ol style="list-style-type: none"> Байгаль хамгаалагч, газрын ажилтнуудын мэргэжлийн болон ажил хэргийн мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх Хэрэглэгчдийг байгаль орчны мэдээллээр хангах экологийн боловсролыг дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалах асуудлаар зөвлөгөөн, сургалт семинар, сурталчилгаа зохион байгуулах <p>Мэдээлэл сурталчилгааны төв, эко гэр ажиллуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа явуулах</p>
8	<p>Архив, бичиг хэргийн эрхлэгч, нярав</p>	<p>Албан хэрэг хөтлөлт</p> <ol style="list-style-type: none"> Иргэдийн өргөдөл гомдол Ирсэн явсан бичиг, хариутай бичгийн шийдвэрлэлт

	ТҮ-5	<ol style="list-style-type: none"> 3. Ирсэн явсан бичгийн бүртгэл, тайлан 4. Хариутай бичгийн хяналт 5. Албан бичиг, тушаал, бусад баримт бичгийг бичиг хэргийн зааврын дагуу бичих 6. Архивын бүрдэлт 7. Ажилтнуудын ажлын цагийн бүртгэл <p>Няравын ажил: Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл хангах</p>
9	Сумдын Байгаль хамгаалагчид /Орон тоо 2/	<ol style="list-style-type: none"> 1. Байгаль орчны хууль тогтоомжийг судалж, нутаг дэвсгэртээ мөрдүүлж, байгаль орчны багц хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын биелэлтийг хангуулах 2. Байгаль орчны хамгаалалт, байгалийн баялгийн зохистой ашиглалтыг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх үйл ажиллагааг зохицуулах 3. Иргэн, ААН, байгууллагын байгаль орчин, баялгийн нөхөн сэргээлтийн гэрээ, хэлцлийн биелэлтэд хяналт тавих 4. Бүх нийтэд байгаль орчин, байгалийн баялаг, байгаль орчны хууль тогтоомжийн болон танин мэдэхүйн сурталчилгааг байнга хийж, энэ үйлсэд олон түмнийг татан оролцуулах, болзошгүй гамшиг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг бүтээлчээр зохион байгуулах 5. Нутаг дэвсгэртээ байгаль орчин, байгалийн баялгийн төлөв байдлын хувьсал өөрчлөлтийн ажиглалт судалгааг тогтмол хийж байгалийн нөхөн сэргээлтийг зохион байгуулах 6. Өөрийн үйл ажиллагааг иргэн, ААН, байгууллага, тэрчлэн баг, сумын Засаг дарга, Тамгын газарт танилцуулж, тэдгээрийн тусламж дэмжлэг, удирдамжийг авч ажиллах 7. Мэргэшсэн байх шаардлагыг ханган мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд байнга анхаарч ажиллах
10	Жолооч ТҮ-3	<ol style="list-style-type: none"> 1. Автомашиныг байгууллагын ажил үйлчилгээнд бэлэн байлгах, эвдрэл гарсан үед байгууллагын даргад мэдэгдэж шаардлагатай сэлбэг, материалыг хугацаа алдахгүй олж бэлдэх, урсгал засварыг цаг хугацаанд нь хийж байх
11	Үйлчлэгч ТҮ-1	<ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын орчинг цэвэр цэмцгэр байлгах, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийх /гэрээгээр/

Торшын удирдлага, эрх зүй,

А.Х. Дорноговь 6 дугаар, шалтгаан байгаа хэмээхээр
нэр